



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА
С.ДАВААСҮРЭН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР**

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Барилгачдын талбай 3, Утас: 26 22 70,
Факс: (976-11) 32 26 83, E-mail: info@gazar.gov.mn

2017.10.30 № 11968

танай _____-ны № _____-т

Хамтран ажиллах тухай

Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 5.1, Монгол улсын Засгийн газрын 2009 оны “Геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоог батлах тухай” дугаар 25 дугаар тогтоол, Монгол улсын 2017 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XI.1.9-д тусгагдсан “Газрын кадастрын мэдээллийн санг солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх” ажлын хүрээнд Газрын кадастрын мэдээллийн санг солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлж, Кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер програм хангамжийг улсын хэмжээнд нэвтрүүлэн ажиллаж байна.

Өмнө нь ашиглаж байсан Пулково (Крассовский)-1942 солбицлын тогтолцооноос Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан WGS-84 (UTM) солбицлын тогтолцоонд шилжсэнтэй холбоотойгоор иргэний өмчийн газрын болон газар дээрх үл хөдлөх эд хөрөнгийн талбайн хэмжээнд тооцооллын хувьд өөрчлөлт орж байгаа тул иргэн, хуулийн этгээдэд чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлэх зорилгоор хуульд заасан эрх хэмжээний хүрээнд талбайн хэмжээ өөрчлөн бүртгэсэн тухай тусгай загвар бүхий тэмдэглэл (дардас)-ийг Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээ (газар, газар дээрх барилга) болон Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээн дээр хийж, шинэчилсэн кадастрын зургийг үнэт цаасан дээр хэвлэн баталгаажуулж иргэдэд үйлчилгээ үзүүлж эхлээд байна.

Иймд банк, банк бус санхүүгийн байгууллагуудад үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн гэрчилгээгээ барьцаанд тавьж буй иргэн, хуулийн этгээдэд чирэгдэлгүй ажиллах талаар холбогдох газруудад чиглэл хүргүүлж, хамтран ажиллана уу.

Тэмдэглэлийн загвар баталсан тушаал болон холбогдох танилцуулгыг хавсаргав.

Хавсралт 3 хуудастай.

ДАРГА  Ц.ГАНХҮҮ

0801703739



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/224

Улаанбаатар хот

Загвар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.12, 23.2.14 дэх хэсэг, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.1, 10.2.5 дахь хэсэг, Засгийн газрын 2009 оны "Геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоог батлах тухай" 25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газрын кадастрын мэдээллийн санг геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлсэнтэй холбоотойгоор талбайн хэмжээг өөрчлөн бүртгэсэн талаар хийх тэмдэглэгээний загварыг хавсралтаар баталсугай.

2. Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ болон Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх /Газар өмчлөх эрх/-ийн гэрчилгээний эхний нүүрний баруун доод буланд уг тэмдэглэгээг хийж байхыг нийслэл, дүүргийн Газрын алба, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, сумын Газрын даамал нарт үүрэг болгосугай.

3. Энэ талаарх мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллах, орон нутагт чиглэл хүргүүлэхийг Кадастрын хэлтэс /Б.Галмандах/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлага, хамтын ажиллагааны газар /Р.Ганхуяг/-т даалгасугай.


ДАРГА



Ц.ГАНХҮҮ

0801700737

Газар зохион байгуулалт, геодези, зураг
зүйн газрын газрын даргын 2017 оны ^{1/220} тоот
тушаалын хавсралт




ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ ЗАГВАР

Газрын кадастрын мэдээллийн санд Засгийн газрын
2009 оны 25 дугаар тогтоолын дагуу WGS-84
солбицол, UTM туслагт шилжсэнтэй холбогдуулан
талбайн хэмжээ м кв/га болж, нэгж
талбарын дугаар болж
өөрчлөгдсөнийг бүртгэв
Огноо
Гарын үсэг
Серийн дугаар

1	Нэр	Талбайн хэмжээг өөрчлөн бүртгэсэн тухай тэмдэглэгээ
2	Хэмжээ	3см х 6см
3	Үсгийн фонд	АпаI
4	Үсгийн өндөр	8
5	Серийн дугаар	Газрын кадастрын мэдээллийн санд хандах эрхийн дугаар

2001 – 2009 оны хооронд “Кадастрын зураглал ба газрын бүртгэл” төслийн хүрээнд Газрын кадастрын мэдээллийн санг “ITRF” солбицлын тогтолцоонд байгуулж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтанд олгогдсон газрыг бүртгэн газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг баталгаажуулан “КАДАСТРЫН ЗУРАГ” – аар үйлчилгээ үзүүлж ирсэн.

Кадастрын зураг



Монгол улсын хэмжээнд байрлал, өндрийн хувьд алдаагүй, талбайн хувьд үнэн зөв, бодит байлгах зорилгоор геодезийн байрлалын сүлжээний хэмжилт, боловсруулалтын ажилд олон улсын геодезийн “WGS” солбицлыг, өндрийн сүлжээнд Балтийн тэнгисийн тогтолцоог, том, дунд масштабын байр зүйн зураглалд дэлхийн хөндлөн меркаторын “UTM” тусгагийг хэрэглэж байхаар Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолыг баталсан.

Дээрх тогтоолыг үндэслэн 2009 оноос шат дараалсан ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд Улаанбаатар хотын хувьд 2017 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс Газрын кадастрын мэдээллийн санг “WGS-84” солбицол, “UTM” тусгагт шилжүүлж эхлээд байна.

Энэхүү системд шилжсэнээр Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтанд олгогдсон газрын талбайн хэмжээ /Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй газрын талбайн хэмжээ болон Газрын улсын бүртгэлийн мэдээлэл дэх талбайн хэмжээ/-нд тооцооллын хувьд өөрчлөлт орж байгаа болно.

Жишээ нь: Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэх газар нь нийслэлийн хэмжээнд 0.07 га буюу 700 м.кв байна гэж заасны дагуу Газрын кадастрын мэдээллийн санд 700 м.кв талбайтайгаар бүртгэгдсэн газар нь Засгийн газрын 25 дугаар тогтоолын дагуу WGS-84 солбицол, UTM тусгагт шилжсэнээр дээрх тооцооллын хувьд 699.44 м.кв талбайтай болж өөрчлөгдөж байна.

Талбайн хэмжээ өөрчлөлтийг дараах байдлаар бүртгэн баталгаажуулна.

1. Шинээр газар өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа болон газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлж буй тохиолдолд Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолын дагуу “WGS-84” солбицол, “UTM” тусгагт бүртгэн баталгаажуулах;
2. Шинээр газар өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа болон газар өмчлөх, эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлж байгаагаас бусад тохиолдолд газрын талбайн хэмжээ өөрчлөгдсөн тухай дардасыг Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ болон Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх /Газар өмчлөх эрх/-ийн гэрчилгээний эхний нүүрний баруун доод буланд даруулж баталгаажуулах;

Дардасны загвар



Талбайн хэмжээн өөрчлөлтийг харуулсан байдал

Д/А	ITRF системд бодогдсон талбайн хэмжээ /м.кв/	Талбайн зөрүү /м.кв/	UTM системд бодогдсон талбайн хэмжээ /м.кв/
1	100	-0.08	99.92
2	200	-0.16	199.84
3	300	-0.24	299.76
4	400	-0.32	399.68
5	500	-0.4	499.6
6	600	-0.48	599.52
7	700	-0.56	699.44
8	800	-0.64	799.36
9	900	-0.72	899.28
10	1000	-0.8	999.2
11	1100	-0.88	1099.12
12	1200	-0.96	1199.04
13	1300	-1.04	1298.96
14	1400	-1.12	1398.88
15	1500	-1.2	1498.8
16	1600	-1.28	1598.72
17	1700	-1.36	1698.64
18	1800	-1.44	1798.56
19	1900	-1.52	1898.48
20	2000	-1.6	1998.4
21	3000	-2.4	2997.6
22	4000	-3.2	3996.8
23	5000	-4	4996
24	6000	-4.8	5995.2
25	7000	-5.6	6994.4
26	8000	-6.4	7993.6
27	9000	-7.2	8992.8
28	10000	-8	9992

WGS-84 солбицол, UTM тусгаг

